



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 01 дүгээр сарын 04
№ 01 /910/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

2

Монгол Улсын
хууль

7

Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн дүгнэлт

31

Хамтын тэтгэврийн тухай

**Гааль, татварын ерөнхий
газрын эрх зүйн байдлын
тухай**

**Эрүүгийн байцаан шийтгэх
хуулийн зарим заалт Үндсэн
хуулийн холбогдох заалтыг
зөрчсөн эсэх маргааныг хянан
шийдвэрлэсэн тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

01.	Хамтын тэтгэврийн тухай	2
02.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	6
03.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	6
04.	Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай	7
05.	Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	17
06.	Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай	18
07.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	19
08.	Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	19
09.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /Шинэчилсэн найруулга/ хуульд нэмэлт оруулах тухай	20
10.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	21
11.	Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	21
12.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	22
13.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	22

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

14.	Тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 114	22
15.	Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай	Дугаар 115	23
16.	Үндэсний статистикийн хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 116	24
17.	Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай	Дугаар 117	24
18.	Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 118	25
19.	Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай	Дугаар 119	25



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|-----|--|------------|----|
| 20. | Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнийг чөлөөлөх тухай | Дугаар 186 | 26 |
| 21. | Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнийг томилох тухай | Дугаар 187 | 26 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|---|------------|----|
| 22. | Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай | Дугаар 439 | 27 |
| 23. | Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай | Дугаар 456 | 28 |
| 24. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай | Дугаар 461 | 30 |
| 25. | Тусгай зориулалтаар 2016 онд агнах агнуурын амьтны тоог тогтоох тухай | Дугаар 463 | 30 |

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- | | | | |
|-----|---|-----------|----|
| 26. | Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 16 | 31 |
|-----|---|-----------|----|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

ХАМТЫН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийгмийн даатгалын сангаас өндөр насны болон цэргийн алба хаасны бүрэн тэтгэвэр авагч нас барсан тохиолдолд түүний эхнэр эсхүл нөхөрт авч байсан тэтгэврийг нь үргэлжлүүлэн олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хамтын тэтгэврийн тухай хууль тогтоомж

2.1.Хамтын тэтгэврийн тухай хууль тогтоомж нь Нийгмийн даатгалын тухай хууль¹, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн

¹ Нийгмийн даатгалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

тухай хууль², энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгоно:

3.1.1.“нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр” гэж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 5-д заасан болзлыг хангасан иргэний авч байгаа өндөр насны тэтгэврийг;

3.1.2.“цэргийн алба хаасны тэтгэвэр” гэж Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан болзлыг хангасан иргэний авч байгаа тэтгэврийг;

3.1.3.“15 ба түүнээс дээш жил хамт амьдарсан эхнэр, нөхөр” гэж гэрлэлтээ бүртгүүлсэн эхнэр, нөхөр өндөр насны тэтгэвэр тогтоолгохоос өмнө 15 ба түүнээс дээш жил хамт амьдарсныг.

4 дүгээр зүйл.Хамтын тэтгэвэр авах эрх

4.1.Энэ хуулийн үйлчлэлд дараах нөхцөлийг хангасан иргэн хамаарна:

4.1.1.нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр эсхүл цэргийн алба хаасны тэтгэвэр авч байгаад нас барсан иргэний 15 ба түүнээс дээш жил хамт амьдарсан эхнэр эсхүл нөхөр;

4.1.2.хамтын тэтгэвэр авагч нь 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй Монгол Улсын иргэн байх.

4.2.Нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр авч байгаад нас барсан иргэний эхнэр эсхүл нөхөр нь энэ хуулийн 4.1.2-т заасан насанд хүрээгүй тохиолдолд түүнд олговол зохих хамтын тэтгэврийг тухайн насанд хүрсэн үед нь олгож эхлэх бөгөөд энэ эрх нь түүний эхнэр эсхүл нөхрийг нас барснаас хойш тав хүртэлх жилийн хугацаанд хадгалагдана.

4.3. Хамтын тэтгэврийг бусдад өвлүүлэхгүй.

² Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн



5 дугаар зүйл. Хамтын тэтгэврийн хэмжээ, олгох хугацаа

5.1.Хамтын тэтгэвэр авах эрх үүссэн иргэнд олгох хамтын тэтгэврийн хэмжээг хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшин, үнэ ханшны өөрчлөлттэй уялдуулан Засгийн газар жил бүр тогтоох бөгөөд хамтын тэтгэвэр нь нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээний 20 хувиас багагүй байна.

5.2.Хамтын тэтгэвэр олгох хугацааны хамрах хүрээг Засгийн газар журмаар тогтооно.

5.3.Хамтын тэтгэврийг нас барсан эхнэр эсхүл нөхрийн өндөр насны тэтгэвэр авах хугацаа дуусгавар болсны дараа эхнэр эсхүл нөхөр нь хамтын тэтгэвэр авахыг хүсч өргөдөл гаргасан өдрөөс эхлэн олгоно.

5.4.Хамтын тэтгэвэр авагчийг нас барснаас хойш 30 хоногийг дуусталх хугацаанд хамтын тэтгэврийг олгоно.

5.5.Энэ хуулийн 4.1.1-д заасан иргэн 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгон авч байсан болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагч байсан бол түүний эхнэр эсхүл нөхөрт олгох тэтгэврийн зардлыг улсын төсвөөс хариуцна.

6 дугаар зүйл.Хамтын тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

6.1.Хамтын тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн иргэн доор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяа нийгмийн даатгалын байгууллагад өгнө:

6.1.1.хамтын тэтгэвэр авахыг хүссэн иргэний маягтын дагуу гаргасан хүсэлт;

6.1.2.иргэний үнэмлэх, түүний хуулбар;

6.1.3.гэрлэлтийн гэрчилгээ, түүний нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;

6.1.4.хүсэлт гаргагчийн болон түүний нас барсан эхнэр эсхүл нөхрийн тэтгэврийн дэвтэр, түүний хуулбар;

6.1.5.эхнэр эсхүл нөхрийн нас барсны гэрчилгээ, түүний хуулбар;

6.1.6.оршин сууж байгаа газрын сум, хорооны Засаг даргын тодорхойлолт.

6.2.Хамтын тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн иргэн нь тэтгэврийн дэвтэргүй бол харьяа аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагаас түүнд шинээр тэтгэврийн дэвтэр олгоно.

7 дугаар зүйл.Хамтын тэтгэврийг тогтоох, олгох тухай

7.1.Хамтын тэтгэвэр олгох ажлыг нийгмийн даатгалын байгууллага зохион байгуулна.

7.2.Нийгмийн даатгалын байгууллагын аймаг, дүүргийн салбар нэгж, сумын байцаагч нь хамтын тэтгэвэр авахыг хүссэн иргэний хүсэлтийг энэ хуулийн 6.1-д заасан баримт бичгийн хамт хүлээн авна.

7.3.Нийгмийн даатгалын байгууллагын аймаг, дүүргийн салбар нэгж нь иргэний хүсэлтийг хүлээн авч, баримт бичгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл хамтын тэтгэврийг олгох тухай шийдвэр гаргаж, хүсэлт гаргасан иргэний тэтгэврийн дэвтэрт тэмдэглэл хийнэ.

7.4.Хамтын тэтгэвэр авах эрх үүссэн иргэний бүрдүүлсэн баримт бичгийг тэтгэвэр авагчийн хувийн хэрэгт хавсаргаж, бүртгэлийн мэдээллийг нийгмийн даатгалын байгууллагын цахим санд байршуулна.

7.5.Хамтын тэтгэвэр авах эрх үүссэн иргэний тухай мэдээлэл, хамтын тэтгэврийн хэмжээ, тэтгэвэр олгох хугацаа, дуусгавар болоход нийгмийн даатгалын байгууллага хяналт тавьж ажиллана.

8 дугаар зүйл.Хамтын тэтгэврийг тогтоож олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулах

8.1.Хамтын тэтгэврийг тогтоож олгохтой холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулна.

9 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

9.1.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 4 дэх хэсэг нэмсүгэй:

“4.Малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нэг жилийг нэг жил хоёр сараар шимтгэл төлж ажилласан хугацаанд тооцно.”

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дугаарыг “5” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.16 дахь заалтын “2016” гэснийг “2018” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛЬ, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Гааль, татварын ерөнхий газрын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

2.1.Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль², Төрийн албаны тухай хууль³, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль⁴, Гаалийн тухай хууль⁵, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль⁶, Татварын ерөнхий хууль⁷, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Гааль, татварын ерөнхий газрын зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой, энэ хуулиар зохицуулснаас бусад асуудлыг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Монгол Улсын Засгийн газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1993 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

³ Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2004 оны 16 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Гаалийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Татварын ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2008 оны 22 дугаарт нийтлэгдсэн.



3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“гааль, татварын алба” гэж энэ хуульд заасны дагуу Гааль, татварын ерөнхий газар буюу Гаалийн тухай хуульд заасан гаалийн байгууллага, Татварын ерөнхий хуульд заасан татварын албыг;

3.1.2.“улсын байцаагч” гэж Гаалийн тухай хууль болон Татварын ерөнхий хуульд заасан гаалийн улсын байцаагч болон татварын улсын байцаагчийг;

3.1.3.“хураагч” гэж Татварын ерөнхий хуулийн 41.1-д заасан ажилтанг;

3.1.4.“гааль, татварын нэгж” гэж Гааль, татварын ерөнхий газрын харьяа гаалийн газар, хороо, салбар, аймаг, нийслэл, сум дүүргийн татварын газар, хэлтэс, тасгийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГААЛЬ, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ТОГТОЛЦОО, УДИРДЛАГА

4 дүгээр зүйл.Гааль, татварын ерөнхий газар

4.1.Гааль, татварын ерөнхий газар нь Монгол Улсын гаалийн болон татварын тухай хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, биелэлтийг хангах, улс, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэх үндсэн чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.

4.2.Гааль, татварын ерөнхий газар нь бэлгэ тэмдэгтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх зааврыг Гааль, татварын ерөнхий газрын дарга батална.

4.3.Гааль, татварын албаны үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

4.4.Гааль, татварын ерөнхий газрын дүрмийг Засгийн газар батална.

5 дугаар зүйл.Гааль, татварын байгууллагын тогтолцоо

5.1.Гааль, татварын байгууллагын тогтолцоо Гааль, татварын ерөнхий газар, түүний харьяа гааль, татварын нэгж, улсын байцаагч, хураагчаас бүрдэнэ.



5.2.Гааль, татварын ерөнхий газрын харьяа гааль, татварын нэгжийн бүтцийг Гааль, татварын ерөнхий газрын дарга батална.

5.3.Гааль, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага харьяа гааль, татварын нэгж, улсын байцаагч, хураагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллана.

6 дугаар зүйл.Гааль, татварын алба, улсын байцаагчийн үйл ажиллагааны зарчим

6.1.Гааль, татварын ерөнхий газар үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, бусдын нөлөөнд үл автах, мэргэшсэн байх, татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, доод шатны байгууллага нь дээд шатны байгууллагад шууд захирагдах зарчмыг удирдлага болгоно.

6.2.Гааль, татварын ерөнхий газар, улсын байцаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд үл автан гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгон ажиллана.

6.3.Хувь хүн, хуулийн этгээд, албан тушаалтан Гааль, татварын ерөнхий газар болон улсын байцаагчаас хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.

6.4.Гааль, татварын алба, улсын байцаагчийн бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлаар хууль тогтоомжоор эрх олгосноос бусад этгээд шийдвэр гаргахыг хориглоно.

6.5.Хууль тогтоомжоор эрх олгосноос бусад тохиолдолд аливаа этгээд татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөхтэй холбогдсон асуудлаар бусдын өмнө үүрэг хүлээхийг хориглоно.

6.6.Гаалийн болон татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, түүний биелэлтийг хангахтай холбогдуулан Гааль, татварын ерөнхий газраас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалыг хуулийн этгээд, хувь хүн дагаж мөрдөнө.

7 дугаар зүйл.Гааль, татварын ерөнхий газрын удирдлага

7.1.Гааль, татварын байгууллагын тогтолцоо нь нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.



7.2.Гааль, татварын ерөнхий газар дарга, асуудал эрхэлсэн гурав хүртэл дэд даргатай байна.

7.3.Гааль, татварын ерөнхий газрын даргыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, дэд даргыг Гааль, татварын ерөнхий газрын даргын саналыг үндэслэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус томилж, чөлөөлнө.

7.4.Гааль, татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн болон харьяа нэгжийн даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу Гааль, татварын ерөнхий газрын дарга томилж, чөлөөлнө.

8 дугаар зүйл.Гааль, татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц

8.1.Гааль, татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.1-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.2.Гааль, татварын ерөнхий газар нь гааль, татварын ажилтнуудыг давтан сургах, мэргэшүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, улсын төсвийн орлого, хяналтын харьяа нэгж, гаалийн лаборатори, эрэлч нохойн алба, гааль, татварын мэдээллийн технологийн нэгжтэй байж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГААЛЬ, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЧИГ ҮҮРЭГ

9 дүгээр зүйл.Гааль, татварын ерөнхий газрын чиг үүрэг

9.1.Гааль, татварын ерөнхий газар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.гаалийн болон татварын тухай хууль тогтоомжийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нэг мөр дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;

9.1.2.гаалийн болон татварын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөх заавар, зөвлөгөө, мэдээллээр татвар төлөгч, хувь хүн, хуулийн этгээдийг ханган сургалт сурталчилгаа явуулж, үйл ажиллагаандаа цахим үйлчилгээ нэвтрүүлэх;

9.1.3.татвар төлөгч хуулийн дагуу төлбөл зохих орлогоо бүрэн гүйцэд тодорхойлж, хугацаанд нь төлсөн эсэхийг хянан шалгах;

9.1.4.хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх;

9.1.5.гаалийн мэдүүлэгч, татвар төлөгчийн талаар мэдээллийн сан үүсгэж, гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлт, татварын хяналт шалгалт, орлого хураалтын үйл ажиллагаанд ашиглах;

9.1.6.анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгүйгээс орлого, зарлагыг нь тодорхойлох боломжгүй этгээдэд хуульд заасны дагуу татвар ногдуулах;

9.1.7.тогтоосон хугацаанд татвар төлөөгүй хуулийн этгээдийн банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг татвараа төлж дуустал түр зогсоох;

9.1.8.татвар, ногдуулах, өр барагдуулах, орлого хураах үйл ажиллагааг Татварын ерөнхий хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасан журмын дагуу явуулах;

9.1.9.илүү төлсөн татварыг татварт суутган тооцох буюу татвар төлөгч хүсвэл тооцоо хийж буцаан олгох;

9.1.10.татвар, торгууль, алданги, хүү төлөхөөс зайлсхийсэн, татвар, гаалийн бүрдүүлэлтийн мэдээ, тайлан болон татвар, гаалийн хяналт шалгалтад шаардлагатай баримт бичгийг хугацаанд нь ирүүлээгүй, түүнчлэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй татвар төлөгч, хувь хүн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэх;

9.1.11.гааль, татварын мэдээллийн системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах;

9.1.12.гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл гаргах, дүн шинжилгээ хийх;

9.1.13.өөрийн тээврийн болон холбооны хэрэгслийг ашиглах боломжгүй нөхцөл, байдлын үед бусдын тээврийн болон холбооны хэрэгсэл ашиглах;

9.1.14.эрсдэл тооцох системд үндэслэсэн гааль, татварын хяналтын стратегийг тодорхойлох;



9.1.15.гааль, татварын хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, бусад холбогдох баримт бичгийг хувь хүн, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй гаргуулан авах;

9.1.16.цахим хяналт шалгалт явуулах;

9.1.17.гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих;

9.1.18.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

10 дугаар зүйл.Гааль, татварын ерөнхий газрын удирдлагын бүрэн эрх

10.1.Гааль, татварын ерөнхий газрын дарга улсын ерөнхий байцаагч байх бөгөөд Гаалийн тухай хууль, Татварын ерөнхий хуульд заасан гаалийн улсын байцаагч, татварын улсын байцаагчийн бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрх хэрэгжүүлнэ:

10.1.1.гаалийн болон татварын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах талаар санал боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Засгийн газарт танилцуулах, гаргасан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

10.1.2.барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн үндэсний код боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах;

10.1.3.харьяа нэгжийн хариуцах хяналтын нутаг дэвсгэрийг тогтоох, эрх хэмжээг тодорхой бараа, тээврийн хэрэгсэл болон гаалийн бүрдүүлэлтийн горимоор хязгаарлах;

10.1.4.улс хоорондын худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, олон улсын стандартын дагуу тогтоосон шалгуурыг хангасан тохиолдолд гаалийн харилцаанд оролцогчид гаалийн итгэмжлэл олгох;

10.1.5.байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг төлөвлөх, хангалтыг зохион байгуулах, албан хаагчдыг томилох, чөлөөлөх, шилжүүлэх, сэлгэж ажиллуулах, шагнаж урамшуулах, төр засгийн шагналд тодорхойлох;

10.1.6.гааль, татварын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх болон татварын орлого бүрдүүлэлтийг сайжруулах зорилгоор иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах;



10.1.7.улсын байцаагчийн эрх олгох, эрхийг хасах, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах;

10.1.8.татварын хяналт шалгалттай холбоотойгоор улсын байцаагчийн үйлдсэн акт, дүгнэлтээс бусад шийдвэрийг хуулийн хүрээнд хянан үзэж, өөрчлөх, хүчингүй болгох;

10.1.9.гаалийн бодлого боловсруулахад оролцох, тарифын болон тарифын бус хязгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

10.1.10.хураагчийн үйл ажиллагааны дүрмийг батлах;

10.1.11.улсын байцаагчид цол олгох, бууруулах, хураах, түдгэлзүүлэх;

10.1.12.хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд гааль, татварын албаны төсөв, хөрөнгийг захиран зарцуулах;

10.1.13.орлого ба хөрөнгийн татварыг давхардуулан ногдуулахгүй байх, татвараас зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын гэрээ болон гаалийн асуудлаар Монгол Улсаас байгуулах олон улсын гэрээний төсөлд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан санал өгөх;

10.1.14.гааль, татварын хууль тогтоомжийн төсөл боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх арга, хэлбэр, боломжийн талаар саналаа бэлтгэж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулах;

10.1.15.гааль, татварын хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргах;

10.1.16.энэ хууль болон гааль, татварын бусад хууль тогтоомжоор олгосон эрхийн хүрээнд нийтээр дагаж мөрдөх журам, заавар, аргачлалыг баталж мөрдүүлэх, зөвлөмж гаргах;

10.1.17.гааль, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг дахин хянуулахаар Маргаан таслах зөвлөл рүү нэг удаа буцаах шийдвэр гаргах;

10.1.18.бараа, тээврийн хэрэгслийг гаалийн хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон энэ хууль болон холбогдох хууль тогтоомжоор эрх олгосон бол дүрэм, журам, заавар, аргачлал батлах, мөрдүүлэх, зөвлөмж гаргах;



10.1.19.зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;

10.1.20.гааль, татварын албыг гадаад, дотоодод болон шүүх, арбитрт төлөөлөх;

10.1.21.татвар ногдуулалт, төлөлт, хураалтад хяналт тавих;

10.1.22.гадаад, дотоод худалдааны төлбөр тооцоонд гааль татварын зорилгоор хяналт тавих;

10.1.23.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

10.2.Гааль, татварын ерөнхий газрын даргын түр эзгүйд түүнийг түүний томилсон дэд дарга Төрийн албаны тухай хуулийн 21.2-т заасан журмын дагуу орлоно.

10.3.Энэ хуулийн 10.1.11-д заасан улсын байцаагчид цол олгох, бууруулах, хураах, түдгэлзүүлэх болон нэмэгдэл олгох журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МАРГААН ТАСЛАХ ЗӨВЛӨЛ

11 дүгээр зүйл.Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагаа

11.1.Гааль, татварын ерөнхий газар болон аймаг, нийслэлийн гааль, татварын нэгжийн дэргэд татварын хяналт шалгалтаар тогтоосон акт, дүгнэлттэй холбогдуулан хувь хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байнгын бус ажиллагаатай Маргаан таслах зөвлөл ажиллана.

11.2.Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааг Татварын ерөнхий хуульд заасан журмын дагуу зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

12 дугаар зүйл.Төрийн бусад байгууллагатай хамтран ажиллах

12.1.Төрийн бүх шатны байгууллага Гааль, татварын ерөнхий газрыг хууль тогтоомжид заасны дагуу шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

12.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь Гааль, татварын ерөнхий газрын харьяа гааль, татварын нэгжийг чиг үүргээ хэвийн хэрэгжүүлэх нөхцөл, бололцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

12.3.Гаалийн болон татварын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд цагдаагийн байгууллага Гааль, татварын ерөнхий газартай хамтран ажиллах бөгөөд дараах үүрэг хүлээнэ:

12.3.1.гааль, татварын алба, улсын байцаагчаас татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн байр, агуулахад нэвтрэн орох болон шалгалт, тооллого, үзлэг хийх, хөрөнгө хураах, битүүмжлэх үйл ажиллагааг хуульд заасны дагуу явуулахад хүч хэрэглэх буюу зохион байгуулалттайгаар эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд шаардлагатай туслалцаа үзүүлж, бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоогоор хангах;

12.3.2.Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг татвар төлөгчөөр бүртгэх, хаягийг тодруулахад шаардлагатай, хувь хүний нууцад үл хамаарах, өөрт байгаа мэдээ, судалгааг гааль, татварын албаны хүсэлтээр гаргаж өгөх;

12.3.3.татвар төлөхөөс зайлсхийж оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжлах ажилд туслалцаа үзүүлэх;

12.3.4.хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын удирдлага нь гааль, татварын албанаас шалгуулахаар шилжүүлсэн татварын хэрэг, зөрчлийг хуульд заасан хугацаанд шалган шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, дүнг гааль, татварын албанд бичгээр мэдэгдэх, түүнчлэн өөрийн илрүүлсэн татварын хууль тогтоомжийн зөрчлийн мэдээллийг гааль, татварын албанд шилжүүлж өгөх.

12.4.Гаалийн болон татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Гааль, татварын ерөнхий газартай хамтран ажиллах бөгөөд шүүхийн шийдвэрийн дагуу өр барагдуулах үйл ажиллагааны явц, үр дүнгийн талаар гааль, татварын албанд улирал тутам бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

12.5.Гаалийн болон татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд улсын бүртгэл болон иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Гааль, татварын ерөнхий газартай хамтран ажиллах бөгөөд Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг гаалийн мэдүүлэгч, татвар төлөгчөөр бүртгэх, хаягийг нь тодруулахад шаардлагатай, хувь хүний нууцад үл хамаарах, өөрт байгаа мэдээ, судалгааг гааль, татварын албаны хүсэлтээр тухай бүр гаргаж өгөх үүрэгтэй.



13 дугаар зүйл.Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага, Хөрөнгийн биржтэй хамтран ажиллах

13.1.Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага гаалийн болон татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар дараах үүрэгтэй:

13.1.1.харилцагч этгээдийн татварын төлбөрийг гааль, татварын албанаас нэр заасан банкинд, уг төлбөрийг хүлээн авсан банк тухайн өдөрт, хэрэв ажлын цаг дууссан бол дараагийн ажлын өдөрт багтаан гааль, татварын албаны харилцах дансаар дамжуулан төрийн сангийн дансанд шилжүүлэх;

13.1.2.татвар төлөгч, хувь хүн, хуулийн этгээд банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоонд шинээр төлбөр тооцоо, хадгаламжийн болон бусад төрлийн данс нээсэн, эсхүл хуучин дансанд өөрчлөлт, хөдөлгөөн хийсэн бол энэ тухай мэдээллийг 10 хоногийн дотор гааль, татварын албанд өгөх.

13.2.Арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллага харилцагчийн өр төлбөрийг дараах дарааллаар гүйцэтгэнэ:

13.2.1.эхний ээлжинд төлүүлэхээр хуульд тусгайлан заасан өр төлбөр. Энэ үүргээ биелүүлээгүй бол гааль, татварын алба гүйцэтгээгүй татварын төлбөрийн дүнгийн тэг аравны гурван хувиар тооцон хоног тутам хүү ногдуулна;

13.2.2.дансан дахь мөнгөн хөрөнгөнөөсөө татвар төлөх тухай татвар төлөгчийн хүсэлт, үл маргах журмаар татвар гаргуулах тухай гааль, татварын албаны шийдвэрт заасан өр төлбөр;

13.2.3.банк, санхүүгийн байгууллага, бусад зээлдэгч, нэхэмжлэгчид төлөх өр төлбөр. Энэ заалтад Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр, тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай⁸ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг хамаарахгүй.

13.3.Хөрөнгийн бирж нь хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн тархалтын талаарх мэдээллийг Гааль, татварын ерөнхий газарт улирал тутам цахим хэлбэрээр гаргаж өгөх үүрэгтэй.

⁸ Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр, тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1996 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



14 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

14.1.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

15 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

15.1.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Үндсэн хууль,” гэсний дараа “ Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/19 дүгээр зүйл:

“19 дүгээр зүйл.Татварын алба

19.1.Татварын албаны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.”

2/34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэг:

“34.3.Татвар төлөгчид акт, дүгнэлтийг хүргүүлснээр гардуулсанд тооцох бөгөөд үүнээс хойш Маргаан таслах зөвлөлд татвар төлөгч гомдол гаргах хугацаа тоологдоно.”

3 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.9 дэх хэсгийн “Үндэсний татварын ерөнхий газрын” гэснийг “Гааль, татварын



ерөнхий газрын” гэж, 74 дүгээр зүйлийн 74.1.11, 74.1.12, 74.1.14 дэх заалтын “албан татвар төлөгчөөр” гэснийг “албан татвар суутган төлөгчөөр” гэж, 74.1.13 дахь заалтын “албан татвар төлөгч” гэснийг “албан татвар суутган төлөгч” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн Дөрөвдүгээр бүлгийн нэр, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэг, 73 дугаар зүйлийн 73.2.5 дахь заалтын “Үндэсний” гэснийг, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсгийн “татвар төлөгч нар гарын үсэг зурж,” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 20-27 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, 71 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлд дараах агуулгатай 7.2.8 дахь заалт нэмсүгэй:

“7.2.8.Гааль, татварын алба хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18³ дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Агентлаг” гэснийг “Хуульд өөрөөр заагаагүй бол агентлаг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Үндсэн хууль” гэсний дараа “Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1 дүгээр зүйл:

“1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн хяналт хэрэгжүүлэх журам, гаалийн бүрдүүлэлтийн горим, нөхцөл, шаардлагыг тогтоох, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”



2/265 дугаар зүйл:

“265 дугаар зүйл.Гаалийн байгууллага

265.1.Гаалийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдох харилцааг Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.”

3 дугаар зүйл.Гаалийн тухай хуулийн 266-272 дугаар зүйл, 281 дүгээр зүйлийн 281.2 дахь хэсэг, 287 дугаар зүйл болон 293-295 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН
ТАТВАРЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.1.28 дахь заалт нэмсүгэй:

“13.1.28.сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг.”

2 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “13.1.20” гэсний дараа “, 13.1.28” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.1.18 дахь заалт нэмсүгэй:

“38.1.18. сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг.”

2 дугаар зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “38.1.14-т” гэснийг “38.1.14, 38.1.18-д” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭДИЙН ЗАСГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “2015 оны 12 дугаар сарын 31-ний” гэснийг “2016 оны 02 дугаар сарын 20-ны” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2016 оны хаврын тариалалтад зориулан 20.0 /хорин/
мянган тонн үрийн улаанбуудайг импортлоход гаалийн албан татвараас
чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс
эхлэн 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж
мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2016 оны хаврын тариалалтад зориулан 20.0 /хорин/
мянган тонн үрийн улаанбуудайг импортлоход нэмэгдсэн өртгийн албан
татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс
эхлэн 2016 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж
мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 114

Улаанбаатар
хот

Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай
хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их
Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2015 оны 11 дүгээр сарын 27-ны
өдөр Улсын Их Хуралд Гааль, татварын ерөнхий газрын эрх зүйн байдлын

тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 115

Улаанбаатар
хот

**Зарим Байнгын хорооны дарга
нарыг сонгох, чөлөөлөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Лувсангийн Эрдэнэчимэг, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Догсомын Батцогт, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Агыпарын Бакей, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэвэлмаагийн Баярсайхан нарыг тус тус сонгосугай.

2.Улсын Их Хурлын гишүүн Сундуйн Батболдыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргын, Улсын Их Хурлын гишүүн Жамъянсүрэнгийн Батсуурийг Эдийн засгийн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 116

Улаанбаатар
хот

Үндэсний статистикийн хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуулийн 1, 2 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сономцэрэнгийн Мэндсайханыг Үндэсний статистикийн хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 117

Улаанбаатар
хот

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Болдын Жавхланг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 118

Улаанбаатар
хот

Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Намдагийн Батцэрэгийг Өргөдлийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Оюунбаатарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Мишигийн Сономпилийг Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Оюунбаатарыг Төсвийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Мишигийн Сономпилийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3.Энэ тогтоолыг 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 119

Улаанбаатар
хот

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх, гишүүнээр томилох тухай

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс Догмидын Сосорбарам, Бямбажавын Цэнддоо, Дамбын Ганбат нарыг тус тус чөлөөлсүгэй.



2.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр Жарантайн Соёл-Эрдэнэ, Содномдоржийн Санасэр, Бадам-Очирын Галаарид нарыг тус тус томилсугай.

3.Энэ тогтоолыг 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 186

Улаанбаатар
хот

**Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнийг
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Дуламын Пунцагийг Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 12 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 187

Улаанбаатар
хот

**Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнийг
томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3, 32.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Сандагийн Нямжавыг Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнээр томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 439

Улаанбаатар
хот

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон явуулж, дүнг 2016 оны IV улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн хороо (Ц.Нанзаддорж)-нд даалгасугай.

2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг Төрийн өмчийн хорооны удирдамж, Үндэсний статистикийн хорооноос баталсан маягт, асуулгын дагуу зохион байгуулж, дүнг 2016 оны III улиралд багтаан Төрийн өмчийн хороонд хүргүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Төрийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулахад шаардагдах зардлыг 2016 оны улсын төсөвт, орон нутгийн өмчийн тооллого явуулахад шаардагдах зардлыг 2016 оны орон нутгийн төсөвт тус тус тусан санхүүжүүлэхийг Сангийн сайд Б.Болорт зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогтод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

С.БАЯРЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 456

Улаанбаатар
хот

Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай

Газрын тухай хуулийн 16.1.13, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үндэсний их баяр наадмын “Монгол наадам цогцолбор”-т зориулан нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт хамаарах 551 га, Төв аймгийн Аргалант сумын нутаг дэвсгэрт хамаарах 12031 га, нийт 12582 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авч, хилийн цэсийг хавсралт ёсоор баталсугай.

2. “Монгол наадам цогцолбор”-ыг байгуулахад шаардагдах зардлыг жил бүрийн улсын болон нийслэлийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Болор, Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл нарт даалгасугай.

3. “Монгол наадам цогцолбор”-ын ерөнхий төлөвлөгөөг батлуулж, холбогдох мэргэжлийн байгууллага, спортын холбоодын дэмжлэг, оролцоотойгоор хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүлд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2015 оны 456 дугаар
тогтоолын хавсралт

“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР”-ЫН ХИЛИЙН ЦЭС

№	Төслийн нэр	Солбицол		Талбайн хэмжээ (га)
		Уртраг	Өргөрөг	
1	Авто зам	106° 31' 34.240"	47° 58' 17.518"	
2	Авто зам	106° 31' 17.983"	47° 57' 16.406"	
3	Авто зам	106° 31' 12.903"	47° 56' 56.189"	
4	Авто зам	106° 31' 10.845"	47° 56' 23.828"	



5	Долоон хөндийд худгийн	106° 32' 35.241"	47° 55' 02.646"	12582
6	Авто зам	106° 31' 32.051"	47° 54' 06.400"	
7	Баянцогт овоо уулын хойд энгэрт	106° 31' 13.541"	47° 53' 43.962"	
8	Завилгаа уулын хойд энгэрт	106° 25' 12.640"	47° 53' 41.171"	
9	Завилгаа уулын хойд энгэрт	106° 24' 01.281"	47° 54' 05.952"	
10	Жирмийн цагаан хөтөл орчим	106° 21' 59.040"	47° 54' 13.363"	
11	Жирмийн цагаан хөтөл орчим	106° 21' 05.408"	47° 54' 07.871"	
12	Жирмийн хөндийд	106° 15' 44.581"	47° 54' 25.606"	
13	Жирмийн хөндийд	106° 07' 35.280"	47° 55' 04.173"	
14	Жирмийн хөндийд	106° 08' 08.211"	47° 56' 50.424"	
15	Жирмийн хөндийд	106° 17' 16.099"	47° 56' 09.628"	
16	Жирмийн хөндийд	106° 18' 26.099"	47° 56' 17.862"	
17	Жирмийн цагаан хөтөл орчим	106° 21' 30.940"	47° 55' 48.169"	
18	Долоон хөндийд худгийн	106° 28' 41.262"	47° 56' 32.205"	
19	Долоон хөндийд худгийн	106° 29' 32.621"	47° 58' 28.848"	
20	Долоон хөндийд худгийн	106° 29' 37.657"	47° 58' 28.379"	
1	Авто зам	106° 31' 34.240"	47° 58' 17.518"	



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 461

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт”-ын “Хоёр. Мал, амьтан нэвтрүүлэх болон үржлийн мал импортлох боомтууд:” гэсэн хэсэгт “13. Дорнод аймгийн Баянхошуу.” гэж, мөн жагсаалтын “Дөрөв. Түүхий мах, дайвар бүтээгдэхүүн экспортлох боомтууд:” гэсэн хэсэгт “14. Дорнод аймгийн Баянхошуу; 15. Сүхбаатар аймгийн Бичигт; 16. Увс аймгийн Тэс; 17. Өмнөговь аймгийн Шивээхүрэн.” гэж, мөн жагсаалтын “Зургаа. Ургамлын үр, үрслэг, суулгац, мал, амьтан болон үржлийн мал экспортлох боомтууд:” гэсэн хэсэгт “3. Дорнод аймгийн Хавирга.” гэж тус тус нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
САЙД**

Р.БУРМАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 463

Улаанбаатар
хот

Тусгай зориулалтаар 2016 онд агнах агнуурын амьтны тоог тогтоох тухай

Амьтны тухай хуулийн 26.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Тусгай зориулалтаар 2016 онд угалз 60, тэх 70, халиун буга 30, саарал чоно 20, бор гөрөөс 10, зэрлэг гахай 10, цагаан зээр 150, агнуурын

шувуу 400 хүртэл толгойг агнуулахаар, тул загас 400 толгойг барьж буцаан тавиулахаар тус тус тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Н.БАТЦЭРЭГ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2015 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар
хот

**Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн
зарим заалт Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан
шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 12.30 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Амарсанаа даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат, Д.Сугар, Д.Наранчимэг, Д.Ганзориг /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Б.Батбаяр, П.Ундрах-Эрдэнэ, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.8, 44 дүгээр зүйлийн 44.3.7 дахь заалт, 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэг Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.



Нэг. Иргэн Б.Батбаяр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй.” гэж зааж Монгол Улсын иргэнд тус эрхийг олгохдоо ямар нэг хязгаарлалт тогтоогоогүй ба шүүхийн шийдвэрт давж заалдах иргэний эрхийг зөвхөн давж заалдах шатны шүүхэд хандах эрхээр хязгаарлахгүйгээр аливаа шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхээр нь хянуулах эрхтэй байхаар тусгасан атал Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх ял оногдуулсан, эсхүл цагаатгагдсан этгээдийн гэм буруутай эсэх асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл энэ хуулийн 304 дүгээр зүйлд заасан журмын дагуу шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогч болон тэдгээрийн өмгөөлөгч гомдол гаргах, Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.” гэж зааж иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч нар давж заалдах шатны шүүхийн магадлалын өөрт холбогдох хэсэгт хяналтын журмаар гомдол гаргах боломжгүйгээр хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх” гэснийг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх..., өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй.” гэж заасныг тус тус зөрчсөн эсэх тухай асуудлаар дүгнэлт гаргаж өгнө үү” гэжээ.

Хоёр. Иргэн П.Ундрах-Эрдэнэ Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 43 зүйлийн 43.3.8 дахь заалтад “шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах

гомдол гаргах.”, 44 дүгээр зүйлийн 44.3.7 дахь заалтад “шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт гомдол гаргах.” гэж заасан нь тэдгээр талуудад зөвхөн анхан шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхийг олгосон бөгөөд харин давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын журмаар гомдол гаргах эрхийг тусгаагүй байна.

Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэгт буюу давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын журмаар гомдол гаргахтай холбоотой харилцааг журамласан хэсэгт “... энэ хуулийн 304 дүгээр зүйлд заасан журмын дагуу шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогч болон тэдгээрийн өмгөөлөгч гомдол гаргах, Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.” гэж зааж, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн тухайд давж заалдах шатны шүүхийн магадлалд гомдол гаргах эрхийг тусгалгүй орхижээ. Өөрөөр хэлбэл давж заалдах шатны шүүхийн шийдвэрт зөвхөн шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогч, тэдгээрийн өмгөөлөгчид гомдол гаргах эрх олгосон байгаа юм.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.8 дахь заалт, 44 дүгээр зүйлийн 44.3.7 дахь заалт, 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсгүүдэд “иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч нар давж заалдах шатны шүүхийн магадлалын өөрт холбогдох хэсэгт хяналтын журмаар гомдол гаргах боломжгүйгээр хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн эсэхийг тогтоож, дүгнэлт гаргаж өгнө үү” гэжээ.

Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

“Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.8 дахь заалт, 44 дүгээр зүйлийн 44.3.7 дахь заалтад тус тус зааснаар иргэний нэхэмжлэгч болон хариуцагч нь шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах эрхтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зохицуулах эрүүгийн байцан шийтгэх ажиллагааны үндсэн зарчим нь гэмт хэргийг илрүүлэх, гэмт



этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зохих ялыг шударгаар оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангах явдал юм.

Харин эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрх, уг нэхэмжлэлийг шүүх эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэх журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 115 дугаар зүйлийн 115.1 дэх хэсэгт заасан байдаг. Үүнээс үзвэл Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үндсэн зорилго нь иргэний нэхэмжлэлийн асуудлыг шийдвэрлэх бус, эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой асуудал юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн тогтоолд гаргасан гомдлыг давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэх хэмжээ, хязгаарыг уг хуулийн 308 дугаар зүйлээр, шүүхийн тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хяналтын шатны шүүхээс хянах журмын 348 дугаар зүйлээр тодорхойлсон.

Ийнхүү тодорхойлсноор шүүхийн тогтоолд гаргасан гомдлыг давж заалдах шатны шүүх бүхэлд нь хянан үздэг бол, хяналтын шатны шүүх зөвхөн Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсэхийг хянах журамтай. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад гаргасан иргэний нэхэмжлэлийг шүүх хамтад нь шийдвэрлэх боломжтой боловч ийнхүү шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг удирдлага болгодоггүй, харин уг нэхэмжлэлд заасан шаардлагад хамааралтай иргэний болон бусад холбогдох хуулийг баримталдаг тул хяналтын шатны шүүхээс Эрүүгийн хуулийг баримтлан шийдвэрлэдэггүй иргэний нэхэмжлэлийн асуудлыг хянан үзэхгүй юм.

Эрүүгийн хуулийн хэрэглээ болон Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны ноцтой зөрчилтэй хамааралгүй асуудлаар хяналтын шатны шүүхэд гомдол гаргах эрхийг уг хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэгт заан олгоогүй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлд заасан Монгол Улсын дээд шүүхийн давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх бүрэн эрхийг болон

мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ” гэх заалт, 48 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно” гэх заалтуудыг зөрчөөгүй байна.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч тус бүр нь өөрийн эрх, ашиг сонирхолтой холбоотой эдлэх эрхийг уг хуулиар тогтоосон бөгөөд иргэний нэхэмжлэгч, хариуцагч нарт хамааралтай иргэний нэхэмжлэлийн асуудлыг Эрүүгийн хуулиар зохицуулдаггүйн улмаас хяналтын шатны шүүхэд гомдол гаргах боломжгүй байгааг Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн заалт, 16 дугаар зүйлийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүллэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй” гэсэн заалтуудыг зөрчихгүй юм.

Дээр дурдсаныг үндэслэн Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.8, 44 дүгээр зүйлийн 44.3.7 дахь заалт, 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус зөрчөөгүй гэсэн тайлбарыг үүгээр танд уламжилж байна.” гэжээ.

Дөрөв. Уг маргаанд холбогдуулан Улсын дээд шүүх Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:



“Хяналтын шатны шүүхээс хэргийн талаар хянавал зохих байдал нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 348 дугаар зүйлийн 348.1 дэх хэсэгт заасан анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсэх нөхцөл байдал юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэгт зааснаар хяналтын журмаар гомдол гаргах, эсэргүүцэл бичих үндэслэл нь давж заалдах шатны шүүх ял оногдуулсан, эсхүл цагаатгагдсан этгээдийн гэм буруутай эсэх асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн тохиолдолд гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчийг шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогч болон тэдгээрийн өмгөөлөгч гомдол гаргах, улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичих эрхтэй байхаар тогтоосон байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.8, 44 дүгээр зүйлийн 44.3.7 дахь заалтад иргэний нэхэмжлэгч, хариуцагч нь шүүхийн тогтоолын зөвхөн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах эрхтэй байхаар тусгажээ. Иймд шүүхээс иргэний нэхэмжлэгч, хариуцагч нь ялтан, цагаатгагдсан этгээдийн гэм бурууг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн асуудлын талаар гомдол гаргах эрхгүйгээр хуульчлагдсан гэж үзэж иргэний нэхэмжлэгч, хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг Улсын Дээд шүүх харьяаллын бусад тооцож хүлээн авахаас татгалзаж ирсэн юм. Энэ шалтгаанаар иргэний нэхэмжлэгч, хариуцагч нар Улсын Дээд шүүхэд иргэний нэхэмжлэлийн асуудлаар гомдол гаргах нь түгээмэл бус байдаг.

Хяналтын шатны шүүхэд гаргаж байгаа гомдол, эсэргүүцлийг анхан шатны шүүхээр дамжуулан гаргадаг тул иргэний нэхэмжлэгч, хариуцагчийн дээрх байдлаар гаргасан гомдлыг мөн шүүхүүдээс буцааж, харин Улсын Дээд шүүх 2012-2015 онд 22 гомдлыг хүлээн авснаас 7 гомдлыг харьяаллын бус гэж үзэн буцааж, 15 гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцжээ. Судалгаанаас үзвэл 15 хэрэгт Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогчийг буруу тогтоосон, тухайлбал хэргийн хохирогчийг иргэний нэхэмжлэгчээр тогтоож эрхийг хязгаарласан

гэсэн гомдол 2, иргэний хариуцагч биш этгээдийг иргэний хариуцагчаар татаж төлбөр гаргуулсан гэсэн гомдол 8, иргэний хариуцагчаар татвал зохих өөр этгээдийг татаагүй гэсэн гомдол 2, иргэний нэхэмжлэгч, хариуцагчийн эрхийг хязгаарласан гэсэн 3 гомдол гаргасныг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэнээс 15 хэргийн 80 хувь буюу 12 хэргийн иргэний хариуцагч, нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгож, 13.3 хувь буюу 2 хэргийн иргэний нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн өмгөөлөгч нарын гаргасан гомдлыг хэлэлцэхгүй орхиж, 6.7 хувь буюу 1 хэргийн иргэний хариуцагчийн өмгөөлөгчийн гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэсэн талаар Улсын Дээд шүүхийн практик судлалын хэлтэс бүртгэсэн байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42, 43, 44 дүгээр зүйлд заасан давж заалдах хяналтын гомдол гаргах эрхийг ялгаатай зохицуулсан. Үндсэн хуулийн цэц Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлд өмгөөлөгч бусад этгээд хяналтын гомдол гаргах эрхийг нээхдээ иргэний нэхэмжлэгч, хариуцагчийг оруулаагүй.

Дашрамд дурдахад хуулийн этгээд, иргэн хэн боловч Үндсэн хуульд зааснаар давж заалдах эрхтэй бөгөөд энэ эрх нь эрх зүйн онол, олон улсын жишгийн дагуу хяналтын шатны шүүхийн шатанд биш давж заалдах шатны шүүхээр хязгаарлагдаж зөвхөн энэ шатанд хэрэгждэг онцлогтойг тэмдэглэж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байхаар заасан. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй болохыг баталгаажуулсан. Гэтэл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.8 дахь заалтад “шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах.”, 44 дүгээр зүйлийн 44.3.7 дахь заалтад “шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт гомдол гаргах.” гэж зааж эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд



иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчаар оролцож байгаа этгээдийн бүх шатны шүүхэд зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар хандах үндсэн эрхийг давж заалдах шатны шүүхээр хязгаарлаж, хэргийн бусад оролцогчтой харьцуулахад тэгш бус байдал бий болгосноороо Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулсан байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 01 дүгээр дүгнэлтэд “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтад “... Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шүүхийн шийдвэрт давж заалдах ...” эрхийг Монгол Улсын иргэнд олгоходоо ямар нэг хязгаарлалт тогтоогоогүй ба шүүхийн шийдвэрт давж заалдах иргэний эрхийг зөвхөн давж заалдах шатны шүүхэд хандах эрхээр хязгаарлахгүйгээр аливаа шүүхийн шийдвэрийг дээд шатны шүүхээр нь хянуулах эрх гэж Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 5-д зааснаар ойлгохоор байна.” гэжээ.

3. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэм хэмжээний дотоод зөрчил, хуулийн хийдэл байгааг дурдах нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.8 дахь заалтад “шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах.”, 44 дүгээр зүйлийн 44.3.7 дахь заалтад “шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт гомдол гаргах.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө

нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах, ... эрхтэй. .”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх,” гэснийг зөрчсөн байна.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.8 дахь заалтад “шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах.”, 44 дүгээр зүйлийн 44.3.7 дахь заалтад “шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт гомдол гаргах.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “ ... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ...” гэснийг; Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх ял оногдуулсан, эсхүл цагаатгагдсан этгээдийн гэм буруутай эсэх асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл энэ хуулийн 304 дүгээр зүйлд заасан журмын дагуу шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогч болон тэдгээрийн өмгөөлөгч гомдол гаргах, Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй. ...”, Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “ ... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.”, Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;”, Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ...” гэснийг зөрчөөгүй байна.



3. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.8 дахь заалтын “шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах.”, 44 дүгээр зүйлийн 44.3.7 дахь заалтын “шүүхийн тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт гомдол гаргах.” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2016 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮД

Ж.АМАРСАНАА

П.ОЧИРБАТ

Д.СУГАР

Д.НАРАНЧИМЭГ

Д.ГАНЗОРИГ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2,5

Индекс: 14003